



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/15

Халбан

Сумын онцгой комиссыг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дэхь заалт, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.3, 40.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 11 дүгээр тогтоолын 1.3, 2.1.10 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор хөнөөлийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх сумын онцгой комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд: Сумын Онцгой комиссын дарга: Сумын Засаг дарга

Сумын онцгой комиссын орлогч дарга: Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүдэд: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны төлөөлөл

Сумын Засаг даргын орлогч

Ерөнхий боловсролын сургуулийн захирал

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч

Эрүүл мэндийн төвийн дарга

Соёлын төвийн дарга

Цаг-Уурын өртөөний эрхлэгч

Хилийн цэргийн 0257 дугаар ангийн 1 дүгээр заставын дарга

Тэсийн-Илч ХХК-ны захирал

Могойн гол ХК-ны захирал

"Эрчим хүч" ХХК-ны техникч

Дэлгэрхаан багийн Засаг дарга

Зуунмод багийн Засаг дарга

Ренчинжугнай багийн Засаг дарга

Уранхайрхан багийн Засаг дарга

Халбан багийн Засаг дарга

Жаргалант багийн Засаг дарга

Бүрхээр багийн Засаг дарга

Цагдаагийн хэсгийн төлөөлөгч

Мал эмнэлгийн үржлийн тасгийн дарга

Улсын бүртгэгч

Санхүүгийн албаны дарга

Газрын даамал

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Зуунмод, Халбан, Жаргалант багийн Байгаль хамгаалагч

Дэлгэрхаан, Бүрхээр багийн Байгаль хамгаалагч

Ренчинжугнай, Уранхайрхан багийн Байгаль хамгаалагч

Нарийн бичгийн дарга: Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Онцгой комиссын ажиллах журмыг боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангуулахыг нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

3. Суманд үүссэн гамшиг осол, аюулт үзэгдлийн үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг төлөвлөх, удирдлага зохион байгуулалтаар хангахад мэргэжлийн анги байгууллагыг удирдлагаар хангаж ажиллахыг сумын онцгой комиссын нийт бие бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

4. Гамшиг аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгохтой хариу арга хэмжээний зардлыг жил бүрийн төсөвт тусган батлуулж ажиллахыг Санхүүгийн албаны даргад үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Цэцэрлэг сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/36 дугаартай захирамжийг хүчингүй болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч даргад даалгасугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

